



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/15

Улаан-Уул

Нөөцийн өвс, тэжээлийн
үнэ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд худалдан авсан нэг боодол өвсний үнийг 18500 (арван найман мянга таван зуу), нэг шуудай хивэгний үнийг 19500 (арван есөн мянга таван зуу), нэг шуудай будааны үнийг 24,000 (хорин дөрвөн мянга), нэг шуудай овъёосны үнийг 29,000 (хорин есөн мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Худалдаж борлуулсан өвс, тэжээлийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлэхийг Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642101189